

НЭГЖ ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ-2 ДУГААР АНГИ

СЭДЭВ:ЭРЧИМ ХҮЧ ҮҮССЭН ТҮҮХ

СУДЛАХ ЦАГ-2

ЗОРИЛГО: ДЭН БОЛОН НҮҮРСНИЙ ТУХАЙ ОЙЛГОЛТ ӨГНӨ.

ЗОРИЛТ:

- ДЭНГИЙН ҮҮСЭЛ ХӨГЖЛИЙГ МЭДЭХ
- НҮҮРСИЙГ ХЭРХЭН ХЭРЭГЛЭДГИЙГ МЭДЭХ

АГУУЛГА:

МЭДЛЭГ	ЧАДВАР
<ul style="list-style-type: none"> • ДЭН • НҮҮРС 	<ul style="list-style-type: none"> • ДЭНГИЙН ҮҮСЭЛ ХӨГЖЛИЙГ МЭДЭХ • НҮҮРСИЙГ ХЭРХЭН ХЭРЭГЛЭДГИЙГ МЭДЭХ

ХАМРАХ ХҮРЭЭ- 2 ДУГААР АНГИ


ХЭРЭГЛЭГДЭХҮҮН: Зурагт үзүүлэн, дэн хийх материал

Хичээлийн сэдэв: Дэн

Үе шат	Суралцахуйн үйл ажиллагаа	Багшийн анхаарах зүйл
Сэдэлжүүлэх	<p>Та нар юунаас айдаг вэ?</p> <ul style="list-style-type: none"> • Сурагчдын айдаг зүйлийг нэрлүүлэх. • Хүүхдүүдийн айдаг зүйлийг харьцуулан ярилцана. <p>Орой болсон үед гэрэл цахилгаан тасраад харанхуй болвол чи яах вэ?</p> <ul style="list-style-type: none"> • гар чийдэн асаана • утасны гэрлээ асаана • лаа асаана <p>Гар чийдэн, утас, лаа байдаггүй байсан үед хүмүүс юуг хэрэглэж харанхуйг гэрэлтүүлдэг байсан бол ? төсөөлөн бодно уу.</p> <ul style="list-style-type: none"> • Хүж • Дэнлүү • Зул 	<ul style="list-style-type: none"> • Сурагчдын айдаг зүйлийг самбарт тэмдэглэх. • Багш бас өөрөө хүүхэд байхдаа харанхуйгаас айдаг байсан тухайгаа ярих.
Ухаарч өргөцүүлэх үе	<p>Багш сурагчдад тос, хөвөн, чүдэнз, тосны суурь таваг үзүүлж үүгээр юу хийж болох талаар ярилцана.</p> <ul style="list-style-type: none"> • Гэрэл гаргагч хийж болох • Зултай төстэй зүйл хийж болох <p>Багш бэлтгэсэн материалаа ашиглан дэн хийж үзүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Суурь тавганд тосоо хийнэ. • Хөвөнгөөр дэнгийн гол хийнэ. • Дэнгийн голоо тосонд дүрж, суулгана. • Дэнгээ асааж үзүүлнэ. <p>Та нар өмнө нь ийм гэрэл гаргадаг зүйлийг харж байсан уу?</p> <p>Үүнтэй төстэй гэрэл гаргадаг зүйл байдаг болов уу?</p> <ul style="list-style-type: none"> • Сурагчдаар яриулж санаа бодлыг нь сонсоно. <p>Дэнг МЭӨ-1 онд анх Хятад улс бий болгожээ.</p>	<ul style="list-style-type: none"> • Юу хийж болох талаар яриулахад анхаарах. • Гал алдах, түлэгдэх аюултай тул ганцаараа туршиж үзэхгүй байхыг анхааруулна. • Дэнгийн үүсэл хөгжлийн талаар таниулна.

Хэрэгжүүлэхийг эрмэлзэх үе	<p>Дэнгийн тухай гүнзгийрүүлэн бодож давуу болон сул талын талаар ярина уу?</p> <ul style="list-style-type: none"> • сул тал-тортог гаргана, үнэр гаргана, гал алдах, салхитай үед салхинд үлээгдэн унтарна, гараа түлэх аюултай. • Давуу тал –харанхуй үед орчныг гэрэлтүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> • Давуу болон сул талыг хэрхэн мэдэрч байгааг анзаарна.
Дүгнэлт	<p>Одоогийн гэрэл гаргагч яагаад бий болсон бол? өөрийн бодлоо бичээрэй.</p>	<ul style="list-style-type: none"> • Дэнд сул тал байсан, хүний оюун ухаан хөгжихийн хэрээр сайжирч одоогийн гэрэл гаргадаг зүйлүүд бий болсон.

Хичээлийн сэдэв: Нүүрс

Үе шат	Суралцахуйн үйл ажиллагаа	Багшийн анхаарах зүйл
Сэдэлжүүлэх	<p>Өвлийн улиралд гадаа маш их утаатай байдаг. Чи утааг хараад юу гэж боддог вэ?</p> <ul style="list-style-type: none"> • Ямар их утаатай байна. • Утааг арилгах юмсан. • Утаа хэзээ арилах бол? • Утаатай байгаа юм чинь амны хаалтаа зүүе. • Утаа эрүүл мэндэд муу. <p>Өвлийн улиралд яагаад их утаатай байгаа юм бол?</p> <ul style="list-style-type: none"> • Айлууд нүүрс түлснээс болж их утаа бий болдог. <p>Нүүрс түлж яадаг юм бэ?</p> <ul style="list-style-type: none"> • Гэрээ дулаацуулдаг. 	
Ухаарч эргэцүүлэх үе	<p>Нүүрсний ач холбогдол болон сул талыг ярина уу?</p> <ul style="list-style-type: none"> • ач холбогдол нь-дулаан ялгаруулдаг. • Сул тал- агаарыг бохирдуулдаг, агаар бохирдсоноос хүний эрүүл мэндэд муу. <p>Нүүрс бидний хэрэглээнд ямар дарааллаар ирдэг вэ? Зөв дэс дараалалд оруулна уу.</p> <p>А.Нүүрсийг ухаж авч, ачаад тээвэрлэнэ. Б.Нүүрсийг ангилж шигшинэ. В.Газрын хөрсийг тэсэлж хөрсийг суллана. Г.Төмөр замаар тээвэрлэж бидний хэрэглээнд ирнэ.</p> <p>Нүүрс бидний хэрэглээнд хэрхэн ирдэгийг зурагт үзүүлэн дээр ярьж тайлбарлана.</p>  <p>Манай орны цахилгаан, дулааныг үйлдвэрлэдэг станцууд нь ихэвчлэн нүүрсээр ажилладаг. Нүүрс бол дулаан гаргахаас гадна цахилгаан гаргаж авах эх үүсвэр болдог гэдэг мэдээллийг сурагчдад өгнө.</p>	

Хэрэгжүүлэхийг эрмэлзэх үе	Нүүрс бидний хэрэглээнд хэрхэн ирдэг талаар зурж үзүүлээрэй.	
Дүгнэлт	Айл өрх бүр нүүрсний хэрэглээгээ хэрхэн багасгаж болох вэ ? бичиж ирээрэй.	

НЭГЖ ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ-2 ДУГААР АНГИ

СЭДЭВ:ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

СУДЛАХ ЦАГ-2

ЗОРИЛГО: ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ ХЭРХЭН ДАМЖДАГ БОЛОН ХЭРХЭН ҮЙЛДВЭРЛЭГДДЭГ ТАЛААР АНХАН ШАТНЫ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ

ЗОРИЛТ:

- ҮЙЛДВЭРИЙН ЗУУХНЫ ТАЛААР МЭДЛЭГТЭЙ БОЛОХ
- ЦАХИЛГААН ДАМЖУУЛАЛТЫН АНХАН ШАТНЫ МЭДЛЭГТЭЙ БОЛОХ


АГУУЛГА:

Мэдлэг	Чадвар
<ul style="list-style-type: none"> • Зуух • Дулаан дамжуулалт 	<ul style="list-style-type: none"> • Үйлдвэрийн зуухыг ялган таних • Дулаан дамжуулалтыг мэдэх

ХАМРАХ ХҮРЭЭ- 2 ДУГААР АНГИ

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН: бичлэг, зурагт үзүүлэн


Сэдэв: Зуух

Үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
Сэдэлжүүлэлт 5 мин	Сурагчдаар үсэгт таавар таалгана. Гурван оронтой хамгийн бага тоон дээр Цагаан толгойн 25 дахь үсгийг нэмэхэд Та биднийг дулаацуулдаг эд болно. Тэр юу вэ? Хүүхдүүдээ.	Сурагчид багшийн асуусан тааварт хариултаа хэлнэ.	100+X=3УУХ
Шинэ мэдлэг олгох 15 мин	Зуухнуудын зурагнуудыг харуулж нэрлүүлэн, зориулалт, ижил болон ялгаатай талыг асууж ярилцана.	Багшийн үзүүлсэн зуухнуудын зургийг ажиглан нэрлээд зориулалт болон хэрэглээг ярилцана.	

Хийхийг эрмэлзэх Үе 10 МИН	Үйлдвэрийн зуухны зургийг харсан төсөөллөө зургаар илэрхийлж зураарай.	Зургийг хараад ойлгосон зүйлийн талаар төсөөллөө зургаар илэрхийлнэ.	 <p>Хэмжээ А3</p>
Дүгнэлт 5 МИН	<p>Эрчим хүч хэрхэн бүтдэг вэ? Бичлэг үзүүлэн тухай бүрт үйлдвэрийн явцын талаар ярилцана.</p> <p>Үйлдвэрийн зуух нь хамгийн том бөгөөд их хэмжээгээр дулаан, цахилгааныг дамжуулах хамгийн эхний шат дамжлага юм.</p>	<p>Үйлдвэрийн зуух нь дулаан цахилгааныг бидэнд дамжуулдаг хамгийн анхны шат дамжлага юм гэдгийг ойлгоно.</p> <p>Эрчим хүч хэрхэн бүтдэг вэ? Бичлэг үзэх. Гэртээ ойлгосон зүйлийнхээ талаар зураг зурна.</p>	<ol style="list-style-type: none"> 1. https://www.youtube.com/watch?v=FccMae5C-wo видео үзүүлэх 2. ДЦС-ын макет гарын доорх материалаар хийнэ.

Сэдэв: Дулаан дамжуулалт

Үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
Сэдэлжүүлэлт 7 Мин	<p>Бидний хэрэглэж буй цахилгаан хэрхэн бидэнд ирдэг вэ? Үйлдвэрлэн гаргадаг юм болов уу? Хаа нэгтэй байж байдаг юм болов уу?</p>	Сурагчид багшийн асуусан асуултанд хариулна.	
Шинэ мэдлэг олгох 10 Мин	<p>Тэгвэл үйлдвэрлэлийн хамгийн эхний дамжлага нь бидний өмнөх хичээл дээр үзсэн халаах зуух юм байна. Цахилгаан эрчим хүчний станцын талаар мэдээлэл өгнө. Монгол улсад байгаа станцуудын талаар ярилцана. ДЦС-4-ийн талаар илүүтэй мэдээлэл өгнө.</p>	Багшийн өгсөн мэдээллүүдийг ойлгосноор цахилгаан хэрхэн бидэн дээр ирдэг талаар мэдлэгтэй болно. Багшийн өгөх мэдээллийг анхааралтай сонсоно.	

<p>Хийхийг эрмэлзэх үе 15 Мин</p>	<p>Цахилгаан хаанаас бидэнд ирдэг вэ? Багш хүүхдүүдийн хариултыг сонсож мэддэг зүйлс дээр нь тулгуурлан цахилгаан дамжин ирж буй зурагт үзүүлэн харуулан тайлбар хэлнэ. -Өөрийн ойлгосон зүйлсийн талаар зургаар илэрхийлээрэй.</p>	<p>Багшийн асуусан асуултанд өөрсдийн мэдлэгийн хүрээнд хариулна. Багшийн өгөх мэдээллийг анхааралтай сонсоно. Өөрсдийн мэдлэгийн түвшинг ахиулна. Ойлгосон зүйлсийнхээ талаар зураг зурна.</p>	 <p>https://www.youtube.com/watch?v=cQetlqg5p98 бичлэг үзүүлэх</p>
<p>Дүгнэлт 3 Мин</p>	<p>Гэртээ: Бид цахилгааныг хэрхэн яаж хэрэглэдэг вэ?</p>	<p>Даалгавраа тэмдэглэж авна.</p>	

НЭГЖ ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ-2 ДУГААР АНГИ

СЭДЭВ: ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ

ЗОРИЛГО: ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААР ОЙЛГОЛТ ӨГНӨ.

ЗОРИЛТ:

- ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААР МЭДЭХ
- АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ САХИЖ МӨРДӨХ

АГУУЛГА:





Мэдлэг	Чадвар
<ul style="list-style-type: none"> • Эрчим хүчний хэрэглээ • Аюулгүй ажиллагаа 	<ul style="list-style-type: none"> • Эрчим хүчний хэрэглээг мэдэх • Аюулгүй ажиллагааг сахиж мөрдөх

ХАМРАХ ХҮРЭЭ: 2 ДУГААР АНГИ

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН: АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗУРАГТ ХУУДАС, ЦАХИЛГААНЫ ХЭРЭГЛЭЭ ЗУРАГТ ХУУДАС






Ээлжит хичээлийн сэдэв: Цахилгааны хэрэглээ

АРГА ЗҮЙ:

№	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа
Сэдэлжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Бид цахилгааныг хаана, хаана хэрэглэдэг вэ? • Танай гэрт цахилгаанаар ажилладаг юу юу байдаг вэ? • Бид өдрийн аль цагт цахилгааныг илүү их хэрэглэдэг вэ? • Яагаад өглөө, оройн цагаар цахилгааныг их хэрэглэдэг гэж бодож байна вэ? • Цахилгаан эрчим хүч бидэнд ямар тустай вэ? Цахилгаанаар ажилладаг зүйлсийг хүснэгтэд байрлуулаарай. <div style="display: flex; margin-top: 10px;"> <div style="width: 50%; height: 20px; background-color: #92d050; border: 1px solid black;"></div> <div style="width: 50%; height: 20px; background-color: #92d050; border: 1px solid black;"></div> </div>	<ul style="list-style-type: none"> • Гэртээ • Ажил дээрээ • Сургууль дээрээ • Бусад газарт хэрэглэдэг. <ul style="list-style-type: none"> ○ Индүү ○ Хөргөгч ○ Тоос сорогч ○ Угаалгын машин ○ Халуун тогоо ○ Ус буцалгагч ○ Зурагт ○ Компьютер..... • Цахилгааныг өглөө, оройн цагаар их хэрэглэдэг. • Хүмүүс өдрийн цагаар гэртээ байдаггүй учраас цахилгаан бага хэрэглэдэг. Харин орой бүгд гэртээ цуглардаг. Гэртээ ирээд хоол хийнэ, зурагт үзнэ, хувцас угаана, компьютер ашигладаг. Иймд цахилгаан их зарцуулдаг. <div style="display: flex; margin-top: 10px;">   </div> <div style="display: flex; margin-top: 10px;">   </div>

Шинэ мэдлэг олгох	<ul style="list-style-type: none"> • Эрчим хүчийг/цахилгааныг / хэрхэн зөв хэрэглэх вэ? Хүүхдүүд ээ • Цахилгаан эрчим хүчний зохистой хэрэглээ гэж юу вэ? Та нар энэ үгийг урьд нь сонсож байсан уу? • Зөв хэрэглээ гэдэг нь зохистой хэрэглээ юм шүү. <ul style="list-style-type: none"> ✚ Маш сайн байна.Хүүхдүүд ээ Бүгдээрээ цахилгаан эрчим хүчээ хэмнэж,зөв зохистой хэрэглэцгээе. ✚ Цонхоор нарны гэрэл тусаж өрөө тасалгааг гэрэлтүүлэхэд бид юуг? яаж хэмнэх вэ? • Манай ангид цахилгаанаар ажилладаг юу юу байна вэ? • Үүнийг бид зохистой хэрэглэж чаддаг уу? Яаж хэрэглэх ёстой вэ? 	<ul style="list-style-type: none"> • Хүн байхгүй өрөөнийхөө гэрлээ унтраана. • Ашиглахгүй байгаа гэрлээ,цахилгаанаар ажилладаг хэрэгслээ унтрааж байх • Зөв хэрэглээг зохистой хэрэглээ гэнэ. ✚ Өрөөнийхөө гэрлийг унтрааж цахилгаанаа хэмнэх хэрэгтэй. Учир нь байгалийн гэрэл орчныг гэрэлтүүлж байна. <ul style="list-style-type: none"> • Гэрэл,хөгжим..... • Өдрийн цагаар ангийнхаа гэрлийг унтрааж хөшгөө нээх хэрэгтэй. • Сонсохгүй үедээ хөгжмөө унтрааж залгуураар нь салгана.
Баататгал	<ul style="list-style-type: none"> • Эрчим хүчийг зөв зохистой хэрэглэх нь яагаад чухал юм бол? • Дараах асуулгын зөв хариултыг олоорой. 	<ul style="list-style-type: none"> • Цахилгаанаа хэмнэнэ • Мөнгөө хэмнэнэ, <ul style="list-style-type: none"> ➢ Эрчим хүчний эх үүсвэрийн гол түүхий эд болох нүүрс нь нөхөн сэргээгдэхгүй, тодорхой хугацааны дараа дуусч үгүй болох аюултай, цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэх, ашиглах нь хүрээлэн буй орчинд нөлөөлж байдаг,эрчим хүчний их хэрэглээ нь дэлхийн цаг уурыг ч өөрчилж чадахаар их хүчтэй иймээс цахилгаан эрчим хүчийг зөв зохистой хэрэглэх хэрэгтэй. • Өрөөнөөс гарахдаа ямар үед гэрлээ унтраах вэ? <ul style="list-style-type: none"> А.Зөвхөн санасан үедээ Б. Унтраах шаардлагагүй В. Үргэлж <ul style="list-style-type: none"> • Танай компьютер залгаатай байх үе нь аль вэ? А. Зөвхөн өдрийн цагаар Б. Зөвхөн хэрэглэж байгаа үедээ В. Өглөө, өдөр, шөнө <ul style="list-style-type: none"> • Чи цахилгаан эрчим хүчийг дэмий үрэхдээ харамсдаг уу? А. Дэмий үрэх бүртээ харамсдаг. Б. Ихэнх тохиолдолд харамсдаг В. Хэзээ ч үгүй. Би чинь жаахан хүүхэд.

Ээлжит хичээлийн сэдэв: Цахилгаан эрчим хүчний аюулгүй ажиллагаа

№	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа
Сэдэл жүүлэх	<ul style="list-style-type: none"> Бид өдөр цахилгаан хэрэгслийг ашигладаг.Цахилгаан хэрэгсэлтэй хэрхэн ажилладаг талаар яриулна. 	<ul style="list-style-type: none"> Цахилгаан хэрэглэлийг хэрхэн залгах, салгах талаар өөрийн үгээр ярина.
Шинэ мэдлэг олгох	<ul style="list-style-type: none"> Ахуйн хэрэглээний цахилгаан хэрэгслийг ажиллуулахдаа зайлшгүй анхаарах зүйлсийг зурагт үзүүлэнгээр таниулна. Хэрвээ чамд ямар нэгэн зүйл хийхэд цахилгаан эрчим хүч ашиглах хэрэг гарвал насанд хүрэгчдээс тусламж аваарай гэдэг санамжийг хэлнэ. Зөв харгалзуулаарай. <p>1. </p> <p>2. </p> <p>3. </p> <p>4. </p> <p>5.  Keep things away from lamp</p>	<p>Сурагчид дараах санамжийг уншаад тохирох зурагтай нь харгалзуулна.</p> <ul style="list-style-type: none"> Цахилгаан дамжуулах утсыг шалбарч гэмтсэн эсэхийг шалгаж байх нь гал гарахаас урьдчилан сэргийлж байгаа хэрэг юм. Цахилгаан дамжуулж буй залгуураас бага насны хүүхдийг хол байлгаж,залгуурыг шүлсдэж норгохгүй байх нь чухал. Учир нь залгуур гэмтэж, хүүхдэд аюул учруулна. Өдрийн гэрлийн бүрхүүл нь халсан байдаг тул түүн дээр шатаж болзошгүй зүйлийг тавьж болохгүй шүү. Суурь залгуурыг хэтэрхий олон залгуураар ачааллуулж болохгүй.Яагаад гэвэл ачааллаа даахгүй эвдэрнэ. Хананаас тэжээлийн залгуурыг угз татаж болохгүй.Татсанаар төхөөрөмж болон залгуурыг гэмтээж гал гарах аюултай.
Баататгал	<ul style="list-style-type: none"> Ангид аюулгүй ажиллагааны булан байгуулна. Цахилгааны аюулгүй ажиллагааг дагаж мөрдөх уриалга гаргана. Гэртээ байдаг цахилгаан хэрэглэлээ зөв ажиллуулахдаа юуг анхаарах талаар зөвлөмж бичээрэй. 	<ul style="list-style-type: none"> Аюулгүй ажиллагааны санамжаас сонгон зургаар дүрсэлж ангид бүтээлийн үзэсгэлэн гаргана. Хүүхдүүд ээ.Цахилгаан хэрэглэлээ эхлээд товчлуураар нь,дараа нь залгуураар нь салгаж хэвшээрэй . Аюулгүй ажиллагааны санамжаа цаг ямагт санаж мөрдөж байгаарай.

НЭГЖ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР-2-Р АНГИ

Сэдвийн нэр: Цахилгаан эрчим хүч хэмнэх боломж

Хамрах хүрээ: 2-р анги

Хугацаа: 35 минут

Зорилго: Гэр бүл эргэн тойрондоо шаардлагагүй үед эрчим хүчээ хэмнэн, байгаль орчиндоо болоод өрхийн төсөвдөө хэмнэлт хийх

Зорилт:

- Гадаа гэрэлтэй үед гэрлээ унтраах
- Цахилгаан хэрэгсэлээ ашиглахгүй үедээ залгуураар нь салгах
- Халуун орчинд халаагуур залгахгүй байх
- Зурагт болон компьютер хэрэглэхгүй үедээ асаалттай орхихгүй байх

Тулгуур үг: Хэмнэлт

Түлхүүр үг: Цахилгаан хэрэгсэл, эрчим хүч, хэрэглээ

Агуулга:

Мэдлэг	Чадвар
<ul style="list-style-type: none"> • Хөргөгчний зөв хэрэглээ • Зурагтны унтраалга • Чийдэнгийн ялгааг таних 	<ul style="list-style-type: none"> ➤ Хөргөгчнөөсөө авах зүйлээ шийдсэн байх ➤ Зурагтаа зөв дарааллаар унтраах ➤ Чийдэнгүүдийн аль нь хамгийн бага эрчим хүч зарцуулах

Хэрэглэгдэхүүн:

А3 дээр эрчим хүч хэмнэлтийн 20 санамж

Арга зүй:

Багш шавийн харилцан яриа

Үе шат	Суралцагчийн үйл ажиллагаа	Багшийн асуулт
Сэдэлжүүлэх	Анхааралтай сонсож, идэвхтэй хичээлд оролцох. Багшийн асуусан асуултанд гараа өргөж хариулах.	Хэмнэлт гэж юу вэ? Бид амьдралдаа хэмнэж чаддаг боловuu?
Шинэ мэдлэг олгох	20 санамжийг ойлгож, дэвтэртээ тэмдэглэж авна. Аав ээждээ энэ талаар танилцуулна.	 <p>Эдгээр санамжуудыг нэг нэгээр нь ойлгомжтой тайлбарлаж өгнө.</p>

<p>Шинэ мэдлэг бататгах</p>	<p>Өөрсдөө эдгээр санамж шиг 3 ширхэг эрчим хүч хэмнэж болох санамж зохион бичнэ.</p>	<p>3 санамж зохиох даалгавар өгөн жишээ танилцуулна.</p> <p>Гадалш гарахдаа болон орой унтахдаа ашиглаагүй цахилгаан хэрэгслээ унтраахдаа залгуураас нь заавал салгаж байгаарай</p> 
-----------------------------	---	--

II анги

Хугацаа: 35 минут

Сорил: 1

[Зөв хариултыг дугуйлна уу.]

1. Улаанбаатар хотын хамгийн их хүчин чадалтай цахилгаан станц аль нь вэ?

- А. ДЦС-4
- Б. ДЦС-3
- В. ДЦС-2


2. Аль нь зөв хэрэглээ вэ?

- А. Утсаа цэнэглэх явцдаа чихэвчээр дуу сонсох
- Б. Унтахдаа зурагтаа унтрах товчлуурыг дараад залгаврыг салгах
- В. Зурагтаа унтраалгүй унтах
- Г. Зурагт үзэхгүй байж асаалттай байлгах

3. Аль нь цахилгааныг хэрэглэдэг зүйлүүд вэ?

- А. Хөлдөөгч, индүү, бөмбөг
- Б. Тоос сорогч, угаалгын машин, зурагт
- В. Уул, үүл, ургамал
- Г. Чийдэн, гэр, компьютер

4. Доорх чийдэнгүүдийн аль нь хамгийн бага цахилгаан царцуулдаг вэ?



5. Аль нь цахилгааныг хэрэглэдэггүй зүйлүүд вэ?

- А. будаа агшаагч, индүү, дээс
- Б. газар, хөлдөөгч, амьтан
- В. уул, үүл, ургамал
- Г. машин, зурагт, халуун тогоо

6. Зурагтыг яаж унтраадаг вэ?

- А. Уртасгагчны товчлуураар унтраадаг
- Б. Зурагтны товчлуураар унтраадаг
- В. Удирдлагаар унтраадаг
- Г. Эдгээр бүгд